

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1.Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2.Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:	3
1.3 Ордын геологийн нөөц	4
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	6
1.5. Уурхайн уурхайн хүчин чадал, ажиллах горим.....	6
1.6.Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал.....	7
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	8
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	9
3.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал	9
3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал	9
3.2.1. Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	10
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	12
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
4.3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	17
5.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.6. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	19
4.7. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	20
4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
4.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	23

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. “Налайх гол-1” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц	5
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим, хүчин чадал.....	6
Хүснэгт 3. Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	10
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	14
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 6. Эвдэрсэн газар техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө	18
Хүснэгт 7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	20
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал.....	21
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
Хүснэгт 12. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал.....	23
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн товчоо	24

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
Зураг 2. Тоосго үйлдвэрлэх төхөөрөмж	7
Зураг 3. Тоосго хатаах талбай.....	7

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“КҮНЛҮН” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо
3	Төслийн нэр	Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төсөл
4	Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт	а. ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9019006127 Улсын регистрийн дугаар: 2745534 Улсад бүртгүүлсэн: 2005.12.19 б. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-009192 Олгосон огноо: 2005.01.24
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол	Талбай: 4.04га Газар зүйн солбилцол 1. 107° 18' 1.36" 47° 44' 45.78" 2. 107° 18' 1.36" 47° 44' 54.78" 3. 107° 17' 54.37" 47° 44' 54.78" 4. 107° 17' 54.37" 47° 44' 45.78"
6	Ордын тоосгоны шаврын анх батлагдсан геологийн бодитой (В) нөөц	183.23 мян.м ³
7	Үйлдвэрлэлийн нөөц	132.05 мян.м ³
8	Жилийн хүчин чадал	Олборлолт: 13.49 мян.м ³
9	Тоосго үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал	4.0 сая ширхэг

1.2.Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:

“Налайх гол-1” тоосгоны шаврын уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 36 км зайд байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино.

Уг орд байрлаж буй нийт 4.04 га талбай бүхий MV-009192 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд хару



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.3 Ордын геологийн нөөц

Ордын нөөцийн АМГ-ын даргын 2010 оны 04 сарын 06-ний өдрийн 138 тоот тушаалаар батлагдсан, ЭБМЗ-ийн 2010 оны 02 сарын 27-ний өдрийн №: ХХ-03-07 тоот дүгнэлт мөн АМГ-ын 2016 оны 08 сарын 01-ний өдрийн Н/91 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2016 оны 07 сарын 05-ний өдрийн №: ХХ-07-02 тоот дүгнэлт тус тус гарсан.

“Күнлүн” ХХК-нь 2016 онд АМГ-ын УУХ-т 2015 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлэн нөөцийн хасалт хийгдсэн. Мөн 2016 онд нэмэлт хайгуулын ажил хийж доод давхаргын 4 блокийн нөөцийг нөөцийн ЭБМЗ-ийг хурлаар батлуулсан байдаг.

2017 онд ТЭЗҮ-ийг боловсруулахдаа дээд давхаргын нөөцийн үлдэгдэл болон шинээр ЭБМЗ-өөр орсон доод давхаргын нөөцөд тулгуурласан байна.

“Налайх гол-1” тоосгоны шаврын ордын геологийн нөөц нь 2017 оны 4-р сарын 21-ний байдлаар 183.24 мян.м³ байна.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг
ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төслийн 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. “Налайх гол-1” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц

№	Нөөцийн блокийн		Хуулах	Ашигт	Хуулах	Ашигт
	дугаар ба	Блокийн	хөрсний	малтмалын	хөрсний	малтмалын
		талбай, м ²	дундаж	дундаж	эзэлхүү н, м ³	нөөц, м ³
	нөөцийн зэрэг		зузаан, м	зузаан, м		
			Дээд давхарга			
1	В-I	1253.00	0.65	2.86	815.00	3584.00
2	В-II	3955.00	0.62	2.70	2452.00	10679.00
3	В-III	13090.00	0.57	2.70	7461.00	34689.00
-	Нийт	18298.00	0.59	2.68	10728.00	48951.60
			Доод давхарга			
4	В-1	11568.38	-	7.24	-	83755.07
5	С-1	2893.27	-	7.80	-	22567.51
6	С-2	2669.81	-	6.90	-	18421.69
7	С-3	1316.32	-	7.25	-	9543.32
-	Нийт	18448.00	-	7.28	-	134287.59
			Ордын нийт нөөц			
8	В нөөц	29866.70	0.36	4.44	10728.00	132707.00
9	С нөөц	6879.40	-	7.35	-	50533.00
	Нийт	36746.00	0.29	4.99	12777.78	183239.19

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 132.05 мян.м³ байхаар ТЭЗҮ-д тооцож тусгасан байна.

1.5. Уурхайн уурхайн хүчин чадал, ажиллах горим

Уурхайн хүчин чадал: Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 13.49 мян.м³ тоосгоны шавар олборлон боловсруулахаар тооцож тусгасан байна.

Уурхайн ажиллах горим: “Налайх гол-1” тоосгоны шаврын уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд 5-р сарын 1-нээс 10-р сарын 1-нийг хүртэл жилд нийтдээ 5 сар ажиллана.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим, хүчин чадал

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	209
3	Жилийн ажиллах хуанлийн хоног	хоног	156
4	Баяр ёслолын амралт	хоног	7
5	Цаг агаарын саатал	хоног	5
6	Засвар үйлчилгээ	хоног	7
7	Олборлолтын ажлын хоног	хоног	153
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8
10	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.8
11	Хоногт ажиллах бодит цаг	цаг	6.4
12	Жилд ажиллах бодит цаг	цаг	1224
13	Уурхайн цагийн хүчин чадал	м ³ /цаг	13.77
14	Уурхайн хоногийн хүчин чадал	м ³ /хоног	88.13
15	Уурхайн жилийн хүчин чадал	м ³ /жил	13485.0

1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал

“Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах дарааллын дагуу явагддаг.

Шавар олборлолт: ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ТООСГОНЫ ШАВАР ОЛБОРЛОЛТ

Тоосго үйлдвэрлэл: ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.

Үүний зэрэгцээ уурхайн тээврийн замыг цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг бууруулах мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд хийгдэнэ.



Зураг 2. Тоосго үйлдвэрлэх төхөөрөмж



Зураг 3. Тоосго хатаах талбай

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Цаг уур: Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй, атмосферийн тунадасны хэлбэлзэл 120-220 мм бөгөөд жилийн дунджаар 200 мм хүрнэ. Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр орох жишээтэй байдаг. Хамгийн халуун нь 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард болдог. Хамгийн их хур тунадас унадаг улирал нь зун байна. Өвөл хөрс нь 3-5 м гүн хөлддөг. Цэвдэгшилт нилээд тархалттай бөгөөд газрын тогтоц, чулуулгийн литологийн бүтцээс хамаарч нам дор газар 1.5-2.0 м, өндөрлөг хэсэгт 3.5-5.0 м-т тохиолдоно. Ордын дүүрэг нь газар хөдлөлтийн VII-VIII бүсэд хамаарна.

Усан сүлжээ: Усан сүлжээний хувьд ордын хойгуур Туул гол урсан өнгөрөх ба Туул голын усны зардал маш тогтворгүй, зун борооны үед голын усны түвшингийн хоногийн хэлбэлзэл 50-60 см-ээр дээшилдэг байна. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70 м, гүн нь 0.8-3.5 м, мөн уулнаас эх авсан жижиг гол горхиуд Туул голд цутгадаг. Ордын зүүн талаар Налайхын гол урсах ба голын хөндийд жижиг тойрмууд тохиолддог байна.

Дэд бүтэц: Дэд бүтцийн хувьд орд нь сайн хөгжсөн бүсэд оршдог, Улаанбаатар хоттой асфальтан зам болон төмөр замаар холбогдсоноос гадна өндөр хүчдэлийн шугам, үүрэн телефоны операторууд бүгд холбогдсон, интернет 4G сүлжээтэй холбогдсон байдаг. “Налайх гол-1” тоосгоны шаврын орд орших Налайхын хотгорын хэмжээнд сүүлийн жилүүдэд Хятад, Монголын 10 гаруй тоосгоны үйлдвэр ажиллаж байна. Улаанбаатар хотын төвөөс төслийн талбай руу 1 цагийн хугацаанд авто машинаар хүрэх боломжтой.

Ургамлан бүрхэвч: Төслийн талбай 1510-1550 м-ийн үнэмлэхүй орчин газарт байрлана. Ургамалжилт-газарзүйн бүсчлэлээр Евроазийн шилмүүст ой, уулын нуга, хээрийн Их мужийн Дорнод Азийн дэд мужийн Монгол-дагуурын Их хошууны Өмнөд Хэнтийн дэд хошууны Өмнөд Хэнтийн нам уулсын тойрогт хамаарна.

Зам харилцаа: Налайх дүүрэг нь зам харилцааны хувьд Улаанбаатар хоттой хатуу хучилттай болон төмөр замаар холбогддог. Чиглэлийн автобус, галт тэрэг болон бусад машин техникийн саадгүй үйлчилгээтэй. Тосгоны баруун талаар Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай зам, хойд талаар Улаанбаатар-Хэнтий чиглэлийн мянганы зам дайрч өнгөрдөг. Зүүн аймгуудын автотээврийн гол зам дайран өнгөрдөг тул зүүн аймгуудтай харилцах зам, харилцааны зангилаа болдог.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон угаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Шавар олборлох уурхайд:

- ✓ Хөрс хуулах, шавар олборлох үед тоос үүсэх,
- ✓ Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос,
- ✓ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий,
- ✓ Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос,
- ✓ Хөрс болон шаврыг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал

Шавар олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

**3.2.1. Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл,
үргэлжлэх хугацаа, эрчим**

Хүснэгт 3.Төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шуудбүс	Өөрөөзохицуулагдах	Богинохугацааны	Уртхугацааны	Бүлэжнөлөөлөх	Буцалгүйнөлөөлөх	Хүчтэй	Дундтэрэг	Багазэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт			X		X					
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X				X		X		X	
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X		X	
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X		X	
Зэрлэг амьтдын орон зай										X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			X							
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	X				X					
Бэлчээрийн байдал			X		X					
Эрдэс түүхий эдийн нөөц	X				X					
Эрчим хүчний нөөц	X				X					
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	X			X						X
Хөрсний эвдрэл, бохирдол			X		X					X
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх			X		X					X
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			X		X					
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		X							X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			X		X					
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			X		X					
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			X		X					
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг
ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төслийн 2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	X								X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X						X			
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X								X	
Ажлын байр нэмэгдэх	X									X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X								X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X								X
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X				X		X		X	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	X						X			X
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	X					X				X
Хүчтэй салхи, уруйн үер	X						X			
Дүн	14	3	15	1	27	1	11		6	11

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Зорилго: “Күнлүн” ХХК-ийн “Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

“Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 23 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвчид төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
 - ✓ Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
 - ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
 - ✓ БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
 - ✓ Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
 - ✓
- БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалаллын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордын төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин				
Уурхай орчимд тоосжилт үүсэх	Ордын овоолго, зам талбайн усалгааны хэмжээ талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардлаар	MNS ISO4227-2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2007, “Агаарын чанар. Техникийн ерөнхий MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга Агаарын тухай хууль 18-р зүйл, MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 4597:2014 “Автозамын тэмдэг. Техникийн ерөнхий MNS 4990:2015 Хөдөлмөр аюулгүй байдал. Эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 6656 : 2017 Хөдөлмөрийн аюулгүй байдал,
	Баюу буюу зуухнаас гарах утаанаас дээж авч стандарттай харьцуулж тайлан боловсруулж түүнд зөвлөмж боловсруулан ажиллах	Жилд 2 удаа	ОХШХ-ийн зардлаас	
	Уурхайн талбайд ашиглагдаж байгаа авто машины хурдныг 30 км/цаг аас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн хэмжээнд	1000.0	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмол хийж хөдөлгүүрээс гарах утаан дахь бохирдуулагч бодисын хэмжээг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах арга хэмжээ авах	2025	90.0	
	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, тоос босохоос хамгаалах элэгдэл, эвдрэлд өртөнө	2025	Үйл ажиллагааны зардал	
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Уурхайн ажилчидаа	Үйл ажиллагааны зардал	

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төслийн
2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Усан орчин				
Газар доорх усны түвшин ашиглалтын улмаас буурах, нөөц хомсдох, бохирдох, гадаргын усны урсац багасгах	Налайх дүүргийн ЗДТГ-тай ус ашиглалтын гэрээг тогтмол байгуулж, ус ашигласны төлбөр тогтмол төлж байх	Ашиглагдах усны хэмжээнээс хамааран орон нутагтай гэрээ хийсэн байх	Үйл ажиллагааны зардал	Усны тухай хууль MNS4943:2015Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага БОАЖ, ЭМ-ийн сайдуудын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А/82/128 тоот тушаалын Хавсралт “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”
Газар доорх ус бохирдох	Эко ОО байгуулах	2025	4000,0	
Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр				
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх, Техноген нөлөөлөөр бохирдох	Шимт хөрсний овоолгыг 2 жилээс дээш хугацаанд хадгалах тохиолдолд олон настаар ургамалжуулах	2025	Үйл ажиллагааны зардалд	MNS 5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт MNS 5917 : 2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
	Газар шорооны болон ажлын үед эвдэрсэн газрыг засч тэгшлэх, нөхөн сэргээх	2025	Нөхөн сэргээлтийн зардалаас	
	Шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй байгуулах	2025	Үйл ажиллагааны зардалд	
	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх	2025	500.0	
	Машин механизмын засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий хатуу хучилттай талбай болон	2021-2025	Үйл ажиллагааны зардал	

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төслийн
2025 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	хайрган хучилттай талбай байгуулах /мөрдөж ажиллах/			
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, ШТМ-ыг түр хадгалах тусгай цэг байгуулж хайрган хучилтай хашаа хамгаалалтай болгох	2025	Дотоод зардлаар	
	Авто зогсоолын талбайг тэмдэгжүүлж, авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох		500.0	
физик нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ				
Үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмын хөдөлгүүрээс үүдэлтэй шуугиан ажиллагсадын эрүүл мэндэд нөлөө үзүүлэх	Техник тоног төхөөрөмжийн шуугиан бууруулах	2025	Дотоод зардлаар	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 163 дугаар тушаалын 02 дугаар хавсралт Дуу чимээ тусгаарлалт БНбД 23-05-10 MNS 5003:2000 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Хөдөлмөрийн эрүүл ахуй, Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
	Дуу шуугиан ихтэй ажлын байранд ажиллагдын сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэлээр хангах			
Нийт		6090.0		

4.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2025 онд ил уурхайн дотоод овоолгоор уулын ажил явагдах бөгөөд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг 0.27 га талбайд хийж 6926.0 мян. төгрөг зарцуулахаар төлөвлөсөн болно.

5. Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нийт үүссэн ухашийн шаардлагатай газруудаар 8%-д дүүргэлт хийгдэнэ. Ухашийн ирмэгийг аюулгүй болгох үүднээс налуулан хэлбэржүүлэхээр төлөвлөж байна. - Дүүргэлт хийсэн, налуулж хэлбэржүүлсэн ухашийн талбайг нийтэд нь жигдрүүлэн тэгшилнэ. - Овоолго байсан талбайг бульдозероор түрж тэгшилнэ.	мян.м³	3500	816.3 төг/м³	2 857.0	1 удаа	MNS 6141:2010, MNS 6138:2010 6258-1:2011 MNS 5918:2023 MNS 5917:2008
Нийт 0.27 га талбайд бүрхэвч ургамал болон олон наст ургамал тарина.	га	0.27	15 сая.төг/га	4069.0	1 удаа	
НИЙТ ДҮН 6926.0						

4.3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн

Арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Тарих газар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн	ширхэг	300	10	3000	Өөрийн талбай дээр тарина.	MNS 5918:2023
НИЙТ ДҮН		3000.0				

4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Эвдэрсэн газар техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Биологийн олон янз байдлыг хамгаалах	Нийслэлийн байгаль орчны газартай хамтран хэрэгжүүлнэ.	2025 он	5000	Төсөл хэрэгжих явцад

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2025	онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.						

4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Уурхай орчимд археологийн дурсгал илрээгүй болно.						
2	Палеонтологийн дурсгал	Уурхай орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.						

4.6.Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

“Күнлүн” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Төлөвлөгөө	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчидад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажиллагсад	Төслийн үйл ажиллагааны хугацаанд	ХАБЭА-ын зардал	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2020 Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Төслийн хүрээнд	Төслийн үйл ажиллагааны хугацаанд	ХАБЭА-ын зардал	
Үйлдвэрийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Удирдлага	Жил бүр	ХАБЭА-ын зардал	MNS 0639:2016, Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо ба тодорхойлолт
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх		Жил бүр	ХАБЭА-ын зардал	
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн нийт ажиллагсад	Төслийн үйл ажиллагааны хугацаанд	ХАБЭА-ын зардал	
Нийт				-	

4.7.Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт-шинжилгээний үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар				
Тоосжилт PM2.5, PM10 Агаар бохирдуулагч SO ₂ , NO ₂	Ажилчдын байр болон бааюу орчмоос	Жилд 2 удаа	500.0	MNS 4585:2016 MNS 5013:2009 MNS 5014:2009
Усан орчин				
Худгийн усны шинжилгээ	Гүний худгаас	Жилд 1 удаа	90.0	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS13.060.50 Усны чанарын стандарт MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Бохир усны шинжилгээ			60.0	
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж, рН, давсжилт,чийгшил NO3 –N, P2O5, K2O, рН, Ca, Mg, Na, K, Cl, SO4, HCO3 Нефть нефтийн бүтээгдэхүүн: Хар тугалга /Pb/ г.м	Ажилчдын байр болон хаягдлын цэг орчмоос 2 цэг	Жилд 1 удаа	2 цэгээс*2 дээж*50.0₮=200.0₮ 45.0₮*2 цэгээс*1 дээж=90.0	MNS5850:2019 “Хөрсний чанар. Хөрс бохирдулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ ISO15799:2003, ISO15799:2005 “Хөрсний чанар. Хөрс болон хөрсний орчны хортой үзүүлэлтүүдийн удирдамж
Төслийг хэрэгжүүлэх зардлын дүн			940.0	

4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хаягдал	Хогийн цэг, бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг сар бүр хийж байх	Хогийн цэг, 00	Сар бүр	400.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Төсөл хэрэгжих талбайгаас 50 метр зай дах хог хаягдал, мөс цасыг цэвэрлэх	Төслийн талбай орчим	Улирал бүр	Дотоод зардлаар	
	“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг Налайх дүүргийн төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	Сар бүр	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах эрх бүхий ААНБ-тай гэрээ хийн нийлүүлэх	Төслийн хүрээнд	3 Сард 1 удаа	Гэрээ байгуулсан дагуу	
	Орчны хог хаягдлыг цэвэрлэх, ариутгах			800.0	
Нийт				1200.0	

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2025 он			
			1-4р сар	5-8-р сар	9-12-р сар	
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг боловсруулж жил бүр батлуулж ажиллах	Дотоод зардаар				БО-ны мэргэжилтэн .
2	Байгаль орчны аудитыг 2 жилд тутамд хийлгэх /мэргэжлийн байгууллагаар/	Гэрээний мөнгөн дүнгээр				Компанийн захирал
3	Орон нутгийн засаг захиргаа хорооны иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож ажиллах	Дотоод зардаар				БО-ны мэргэжилтэн
4	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх	Дотоод зардаар				Уурхайн дарга
5	Газрын чанарын улсын хянан баталгааг 2 жил тутамд 1 удаа хийлгэх	Гэрээний мөнгөн дүнгээр		Тухай бүрт нь		Уурхайн дарга
6	Газрын чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд 1 удаа хийлгэх	Гэрээний мөнгөн дүнгээр				Байгаль орчны мэргэжилтэн
7	Палеонтологи, археологи, угсаантны зүйн хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гэрээний мөнгөн дүнгээр				Уурхайн дарга

4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 12. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	“Күнлүн” ХХК-ийн холбогдох удирдлага, “Эхопланет” ХХК	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр дүн, дараа жилийн БОМТ	10 сарын 15 ны дотор	БО-ны мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар	“Күнлүн” ХХК-ийн байранд
2	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт тайлагнах	Хэвлэмэл тайлан		11 сарын 01 ны дотор	БО-ны мэргэжилтэн		НБОГазар
3	Төслийн харьяаллын хорооны ИНХ, төслийн талбай орчмын оршин суугчид	Хэвлэмэл болон цахим тайлан		11 сарын 01 ны дотор	Уурхай болон үйлдвэрийн БО хариуцсан мэргэжилтэн	300.0	Налайх дүүргийн Тамгын газрын байр
4	БОАЖЯ	Ажлын тайланг хянуулж, төлөвлөгөөг батлуулах		12 сарын 15 ны дотор		500.0	БОАЖЯ
	Нийт:					800.0	

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

“Күнлүн” ХХК-ийн байгаль орчны менежментийн зардлын тооцоо: Байгаль орчныг хамгалаах менежментийн төлөвлөгөөнд нийт **23156.0** мян. төгрөг төлөвлөв. 2025 оны БОМТ-ний баталгаа нь 11578 мян. төгрөг байршуулав.

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн товчоо

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд	Жилд /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хөтөлбөр	6090
2	Нөхөн сэргээлтийн зардал	6926
3	Дүйцүүлэн хамгаалах зардал	5000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	940
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1200
6	Оршин суугчидад танилуулах	800
7	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн (300 мод)	3000
	Нийт зардал	23156